



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 16 (589)

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- *Ерөнхийлөгчийн хоригийн тухай*

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Нийтийн биеийн тамир, спортын талаар авах зарим арга хэмжээний тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2009 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын хэвлэл

2009 оны дөрөвдүгээр сарын 27 №16 (589)

Улаанбаатар хот

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- |      |   |     |
|------|---|-----|
| 207. | Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 383 |
| 208. | Гэрээ соёрхон батлах тухай  | 383 |

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- |      |   |           |     |
|------|---|-----------|-----|
| 209. | Ерөнхийлөгчийн хоригийн тухай                             | Дугаар 28 | 384 |
| 210. | Үндсэн хуулийн цэцийн 2009 оны 02 дугаар дүгнэлтийн тухай | Дугаар 29 | 384 |

### Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- |      |   |           |     |
|------|---|-----------|-----|
| 211. | Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай                                    | Дугаар 56 | 384 |
| 212. | Өлзий-Утасын Баярмагнайд Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээх тухай      | Дугаар 57 | 389 |
| 213. | Гомбын Мямарнаранд Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээх тухай            | Дугаар 58 | 389 |
| 214. | Адилбишийн Нэргүйд Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээх тухай            | Дугаар 59 | 389 |
| 215. | Тувааны Цолмонд Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээх тухай               | Дугаар 60 | 389 |
| 216. | Баастын Пүрэвт Монгол Улсын гавъяат хуульч цол хүртээх тухай                | Дугаар 61 | 390 |
| 217. | Долгорын Сэд-Очирт Монгол Улсын гавъяат эдийн засагч цол хүртээх тухай      | Дугаар 62 | 390 |
| 218. | Мятавын Лхамсүрэнд Монгол Улсын гавъяат эдийн засагч цол хүртээх тухай      | Дугаар 63 | 390 |
| 219. | Даржаагийн Насанжаргалд Монгол Улсын гавъяат эдийн засагч цол хүртээх тухай | Дугаар 64 | 390 |

### Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- |      |   |           |     |
|------|---|-----------|-----|
| 220. | Нийтийн биеийн тамир, спортын талаар авах зарим арга хэмжээний тухай        | Дугаар 05 | 391 |
| 221. | Хөтөлбөр батлах тухай   | Дугаар 10 | 393 |
| 222. | Хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай | Дугаар 12 | 398 |

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 04 дүгээр сарын 09-ны өдөр

Улаанбаатар хот

### ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2009 оны 3 дугаар сарын 12-ны өдөр батлагдсан Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн "Төрийн албаны" гэснийг "Улс орныг хамарсан санхүү, эдийн засгийн хямралыг даван туулах онцгой арга хэмжээ авахаас бусад тохиолдолд төрийн албаны" гэж тус

тус" гэснийг хассугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь буюу 2009 оны 4 дүгээр сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА

Н.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

### ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Иргэний болон худалдааны хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс хоорондын гэрээг Монгол Улсын

Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 04 дүгээр сарын 09-ны өдөр

Дугаар 28

Улаанбаатар хот

### Ерөнхийлөгчийн хоригийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. 2009 оны 3 дугаар сарын 12-ны өдөр батлагдсан Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн Төрийн албаны тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь

хэсэгт оруулсан өөрчлөлтөд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс тавьсан хоригийг хүлээн зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс буюу 2009 оны 4 дүгээр сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА

Н.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 04 дүгээр сарын 09-ны өдөр

Дугаар 29

Улаанбаатар хот

### Үндсэн хуулийн цэцийн 2009 оны 02 дугаар дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын үндсэн хуулийн цэцийн 2009 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 02 дугаар дүгнэлтийн "Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсгийн "Хурлын бүрэн эрхийн хугацааны 50-иас илүү хувь өнгөрсөн тохиолдолд тухайн Хурлыг энэ хуулийн 15.1.1, 15.1.2-т заасан үндэслэлээр тараахыг хориглоно" гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Ардчилсан ёс, шударга ёс, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэсэн заалтыг зөрчсөн байна" гэсэн хэсгийг хүлээн зөвшөөрсүгэй.

2. Монгол Улсын үндсэн хуулийн цэцийн 2009 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 02 дугаар дүгнэлтийн "Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай

хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсгийн "... эсхүл дээд шатны..." гэсэн заалт, тус зүйлийн 25.5 дахь хэсгийн "Аймаг, нийслэлийн Хурлын шийдвэр нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй бол түүнийг Улсын Их Хурал өөрчлөх буюу хүчингүй болгох эрхтэй" гэсэн заалт нь Монгол Улсын үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэх...", мөн зүйлийн 2 дахь хэсгийн "Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэх үл болно..." гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна" гэсэн хэсгийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

3. Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс буюу 2009 оны 4 дүгээр сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА

Н.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 03 дугаар сарын 13-ны өдөр

Дугаар 56

Улаанбаатар хот

### Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, боловсрол, соёл урлаг, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, уул уурхай, эрчим хүч, дулаан, хэвлэл мэдээлэл,

төр захиргааны болон төрийн бус байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

### ХӨДӨЛМӨРИЙН ГАВЪЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Чимэддаваагийн Адъяасүрэн - Төв аймгийн Татварын хэлтсийн дарга  
2. Нацагдоржийн Амгалан - Үндэсний дуу бүжгийн эрдмийн чуулгын дуучин  
3. Бөехүүгийн Винтов - Орхон аймгийн Гаалийн газрын дарга

4. Цэрэнпилийн Дуламсүрэн - Нийслэлийн барилгын "Сүлд уул" ХХК-ийн даамал, сэргээн засварлагч  
5. Гомбожавын Занаа - Хөгжим бүжгийн коллежийн багш  
6. Ванчинсүрэнгийн Лхагварачаа - П.Н.Шастины нэрэмжит Клиникийн төв эмнэлгийн оношлогооны төвийн их эмч

7. Батын Лхамжав - Нийслэл дэх өмгөөлөл, хууль зүйн зөвлөгөө өгөх "BDLC" ХХК-ийн захирал, ахмад хуульч

8. Базаргочоогийн Надмид - Батлан хамгаалах яамны Төрийн захиргааны удирдлагын газрын мэргэжилтэн

9. Чогдонгийн Тогтох - МҮОНРТ-ийн теле операторын албаны зураглаач

### "АЛТАНГАДАС" ОДОНГООР:

1. Нямцэрэнгийн Агваан - Төв аймгийн нийтийн аж ахуйн "Төв-Ус" ХК-ийн бригадын дарга

2. Тангадын Бааваа - МҮОНРТ-ийн ахмад ажилтан

3. Дамдинжавын Баатар - Төв аймгийн "Ар жанчивал" рашаан сувиллын захирал

4. Равжилын Бадам - Монгол цэргийн музейн аж ахуйн дарга

5. Сүрэнхэрийн Бадамдорж - Нийслэлийн "Мэдээлэл холбооны сүлжээ" ХК-ийн засварын инженер

6. Доржийн Бадмаанямбуу - Нийслэлийн эрүүл мэндийн "Болор мэлмий" нүдний эмнэлгийн мэс заслын сувилагч

7. Чойжилнамсрайн Батмөнх - Нийслэлийн Баянгол дүүргийн өндөр настан, армийн музейн зураач, асан

8. Лхүүндэвийн Батнасан - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 11 жилийн 24 дүгээр сургуулийн сургалтын менежер

9. Цэдэвийн Батсүх - Увс аймгийн Нисэх буудлын дарга

10. Дамирангийн Баяннамсрай - Д а р х а н - Уул аймгийн Шарын гол сумын Засаг дарга

11. Дүгэржавын Бийцээ - Ховд аймгийн Булган сумын малчин

12. Доохүүгийн Бишхүү - Орхон аймгийн Баян-Өндөр сумын өндөр настан, ахмад эдийн засагч

13. Бат-Очирын Бямбадаш - Улсын Клиникийн нэгдсэн эмнэлгийн Бөөр судлалын клиникийн эрхлэгч

14. Бажуудайн Ганбаатар - УБТЗ-ын Улаанбаатар дахь вагон депогийн дарга

15. Лхаасүрэнгийн Галсумъяа - Анагаах ухааны хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан

16. Баясгалангийн Давааням - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 13 дугаар хорооны Засаг дарга

17. Нямрагчийн Дашням - ШУТИС-ийн Эрчим хүчний инженерийн сургуулийн профессорын багийн багш

18. Нямсүрэнгийн Дашцэрэн - Төв аймгийн нийтийн аж ахуйн "Төв-Ус" ХК-ийн бригадын дарга

19. Чилхаасүрэнгийн Дуламсүрэн - Клиникийн 1 дүгээр амаржих газрын эх баригч эмч

20. Ендонгийн Думаа - ХААИС-ийн химийн тэнхимийн багш

21. Жигжидийн Лхагвасүрэн - Нийслэл дэх "Багш нарын мэргэжил дээшлүүлэх институт"-ийн арга зүйч

22. Өлзийбатын Лхагвасүрэн - Нийслэлийн Баянзүрх дүүргийн 2 дугаар хорооны өндөр настан

23. Бизьяагийн Лхамсүрэн - Нийслэлийн Налайх дүүргийн 109 дүгээр сургуулийн бага ангийн багш

24. Гочоогийн Лувсандагва - Булган аймгийн Могод сумын малчин

25. Мангалжавын Налжирмаа - Нийслэлийн Баянгол дүүргийн 164 дүгээр цэцэрлэгийн багш

26. Баавайн Нарангэрэл - "Бөртэ" Төрийн

10. Ванчигийн Удвал - МАХН-ын удирдах зөвлөлийн гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд

11. Бат-Өлзийгийн Цэрэндаш - Анагаах ухааны хүрээлэнгийн төслийн удирдагч, академич

12. Эрдэнэбатын Эрдэнэчулуун - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн иргэн, Монгол Улсын тод манлай уяач

13. Доржсүрэнгийн Наранбаатар - МҮОНРТ-ийн ерөнхий захирал

14. Хасын Нацагдорж - БХИС-ийн БХЭШХ-ийн эрдэм шинжилгээний дэд ажилтан

15. Доржжавын Нина - Төр, засгийн үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын харьяа хэвлэл үйлдвэрийн дэвтэрлэгч

16. Шаравдоржийн Норжмаа - "Кредит" банкны Дархан-Уул аймаг дахь тооцооны 7 дугаар төвийн захирал

17. Цэдэвийн Нямжамаа - Нийслэлийн уул уурхайн "Монголчехметалл" ХХК-ийн экскаваторчин

18. Намдардоржийн Пүрэвэ - Нийслэлийн Шүүхийн шүүгч, уран сайханч

19. Ядамжавын Пүрэвэ - Нийслэл дэх уул уурхайн "Монголросцветмет" ХХК-ийн үйлдвэрлэл хариуцсан хэлтсийн дарга

20. Цултэмсүрэнгийн Рагчаа - Төв аймгийн Борнуур сумын "Бичигт" багийн өндөр настан, ахмад багш

21. Жанимханы Сауле - Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд

22. Жадамбаагийн Сүнжидмаа - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 15 дугаар хорооны Иргэдийн Нийтийн Хурлын дарга

23. Дагвадоржийн Тунгалаг - Нийслэл дэх "Сүү" ХК-ийн маркетингийн ахлах менежер

24. Дашцэрэнгийн Тогоохүү - Төв аймгийн үйлдвэрлэл, үйлчилгээний "Ажлын хувцас" ХК-ийн механикч

25. Ядамцогийн Товуухорол - УБТЗ-ын Тээвэр зохион байгуулалтын албаны ахлах байцаагч

26. Ядамжавын Хажидмаа - Говь-Алтай аймгийн Шарга сумын Засаг даргын Тамгын газрын дарга

27. Чоймболын Хаянхярваа - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 15 дугаар хорооны өндөр настан

28. Чинбатын Хишигмаа - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 11 жилийн 67 дугаар дунд сургуулийн захирал

29. Цэвэгийн Цэвээнбалжир - Нийслэлийн уул уурхайн "Багануур" ХК-ийн хөдөлмөр хамгааллын инженер

30. Долгорын Цэдэнбалжир - Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын малчин

31. Цэдэндоржийн Чагнаадорж - Т ө р , засгийн үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын харьяа хэвлэл үйлдвэрийн хянагч

32. Базардагзальын Чинбат - Нийслэлийн эрчим хүчний "Улаанбаатар Дулааны сүлжээ" ХК-ийн гагнуурчин

33. Даваагийн Чулуун - Орхон аймгийн "Эрдэнэт" цоцолбор сургуулийн монгол хэл, уран зохиолын багш



**ЦЭРГИЙН ГАВЪЯАНЫ ОДОНГООР:**

1. Пүрэвийн Банзрагч - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 17 дугаар хорооны өндөр настан, ахмад дайчин
2. Мягмарсүрэнгийн Батчулуун - Хилийн 0164 дүгээр ангийн төв агуулахын дарга, дэд хурандаа
3. Сэмжидийн Баясгалан - Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын офицер, дэд хурандаа
4. Сэдийн Галсанцэдэн - Нийслэлийн Хан-Уул дүүргийн өндөр настан, Цэргийн дуу бүжгийн чуулгын багш асан
5. Нацагийн Дөш - Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын өндөр настан, ахмад офицер

6. Дамдиндоржийн Мөнхбат - Хилийн 0168 дугаар ангийн техникийн ангийн дарга, хурандаа
7. Самбуудоржийн Ооёо - Өмнөговь аймгийн Даланзадгад сумын өндөр настан, ахмад офицер
8. Дандийн Цэрэнжав - Хилийн 0243 дугаар ангийн хилийн албаны ажилтан, дэд хурандаа
9. Чойжоогийн Чинзориг - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн цагдаагийн хэлтсийн эрүүлжүүлэх байрны дарга, цагдаагийн хошууч
10. Бадарчийн Энхжаргал - Батлан хамгаалах яамны Гадаад хамтын ажиллагааны газрын дарга, хурандаа

**ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:**

1. Намдагийн Адъяа - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн математикийн гүнзгийрүүлсэн сургалттай 11 дүгээр сургуулийн багш
2. Адъяагийн Амаржаргал - БХИС-ийн Удирдлага технологийн арга зүйн багш
3. Нарангэрэлийн Амарзаяа - Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын хяналтын улсын байцаагч
4. Должингийн Алтанцэцэг - "Бөртэ" Төрийн өмчит үйлдвэрийн газрын оёдолчин
5. Санжаагийн Алтанцэцэг - Батлан хамгаалахын их сургуулийн Эмгэг судлал, шүүх эмнэлгийн лаборант
6. Гарамрагчаагийн Ариунболд - Нийслэлийн Баянзүрх дүүргийн 11 жилийн 21 дүгээр дунд сургуулийн захирал
7. Сэрчмаагийн Баасандорж - Нийслэлийн соёл урлагийн дуу, дүрс бичлэгийн "SHINE" студийн дэргэдэх "Харш" хамтлагийн дуучин
8. Бэгзжавын Бадамчулуун - Нийслэлийн Баянзүрх дүүргийн 87 дугаар дунд сургуулийн бага ангийн багш
9. Баасандамбын Батбаяр - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 11 жилийн 50 дугаар сургуулийн монгол хэлний багш
10. Бямбаагийн Батцэцэг - Хилийн 0108 дугаар ангийн шатахууны нярав
11. Доржийн Баяраа - Төр, засгийн үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын авто баазын агрегат засварчин
12. Санзайн Борхүүхэн - Хавдар судлалын үндэсний төвийн сувилагч
13. Пүрэвийн Болдбаатар - Нийслэлийн эрчим хүчний "Улаанбаатар Дулааны сүлжээ" ХК-ийн албаны дарга
14. Баярын Будсүрэн - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн "Мөнхбаясгалант" өрхийн эмнэлгийн их эмч
15. Лхамжавын Галбат - Нийслэлийн эрчим хүчний "Улаанбаатар Дулааны сүлжээ" ХК-ийн дулааны оруулгын слесарь
16. Гарваагийн Гэрэмжав - Нийслэлийн Еэгануур дүүргийн Байгалийн голомтот халдеарт өвчин судлалын үндэсний төвийн тархвар судлагч их эмч
17. Норовын Гиймаа - Хавдар судлалын үндэсний төвийн их эмч
18. Гэндэнгийн Гэрэлбаатар - Тагнуулын ерөнхий газрын дээд сургуулийн үйлчлэгч

19. Шарын Даваажав - Клиникийн 1 дүгээр амаржих газрын сувилагч
20. Лувсанбатын Даваахүү - Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын газар тариалангийн "Баян-Ундарга" ХХК-ийн механик
21. Ламжавын Дарьсүрэн - Орхон аймгийн "Орхон" доцголбор сургуулийн бага ангийн багш
22. Чүлтэмжамцын Дашзэвэг - Хэнтий аймгийн Хэрлэн сумын 1 дүгээр сургуулийн хими-биологийн багш
23. Чүлтэмдамийн Дашиймаа - Хавдар судлалын үндэсний төвийн сувилагч
24. Үрчгэрийн Дашдондог - Зэвсэгт хүчний 124 дүгээр ангийн авто, холбоо тусгай техникийн нярав
25. Намжилын Довчинорол - Нийслэлийн гоц авьяастай хүүхдийн 93 дугаар сургуулийн монгол хэл, уран зохиолын багш
26. Догсомын Долгорсүрэн - БХИС-ийн Ар тал, техникийн хангалтын албаны хүнсний нярав
27. Гаваагийн Должинсүрэн - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 24 дүгээр сургуулийн бага ангийн багш
28. Балжиннямбуугийн Дорж - ШУТИС-ийн Компьютерийн техник менежментийн сургуулийн ахлах багш
29. Найдангийн Дэмбэрэлдорж - Ховд аймгийн Аудитын газрын аудитор
30. Жамсрангийн Жаргалмаа - Монголын дүлий иргэдийн эрхийг хамгаалах "Энэрэл эв эе" холбооны удирдах зөвлөлийн дарга
31. Самдангийн Лантуу - МУИС-ийн геофизикийн судалгааны төвийн ахлах багш
32. Насан-Очирын Лхагва - Зэвсэгт хүчний Клиникийн төв госпиталийн мэс заслын нэгдсэн тасгийн хагалгааны сувилагч
33. Банзрагчийн Лхагвасүрэн - Хэнтий аймгийн зам засварын "Харгуй" ХХК-ийн гүүр хамгаалагч, жолооч
34. Жамцын Лхамсүрэн - Нийслэлийн эрчим хүчний "Улаанбаатар Дулааны сүлжээ" ХК-ийн дулааны оруулгын слесарь
35. Цэдэнгомбын Лхагвасүрэн - Улсын Клиникийн төв эмнэлгийн хагалгааны сувилагч
36. Бадамдоржийн Минжүүр - Зэвсэгт хүчний Клиникийн төв госпиталийн нөхөн сэргээх уламжлалт эмчилгээний тасгийн сувилагч
37. Санжидийн Мондоо - Төр, засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын авто баазын



жолооч

38. Хадын Мөнгөнцэцэг - Төв аймгийн Бүрэн сумын сургуулийн бага ангийн багш

39. Жамсрангийн Нарантуяа - Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн эмнэлгийн асрагч

40. Чойговын Нарантуяа - Орхон аймгийн "Орхон" цогцолбор сургуулийн бага ангийн багш

41. Чойсүрэнгийн Наранцэцэг - Нийслэлийн Баянгол дүүргийн 11 жилийн 28 дугаар сургуулийн түүх, нийгмийн багш

42. Рэнцэнгийн Нүрээд - Увс аймгийн Улаангом сумын Хот тохижилт компанийн тракторын жолооч

43. Гончигийн Одонтуяа - Хөвдөр судлалын үндэсний төвийн туяа эмчилгээний тасгийн эрхлэгч, их эмч

44. Ёндонгийн Отгонбаяр - Нийслэлийн Баянзүрх дүүргийн 92 дугаар дунд сургуулийн багш

45. Авирмэдийн Оюун - Клиникийн 1 дүгээр амаржих газрын мэс заслын сувилагч

46. Агваандоржийн Оюумаа - Булган аймгийн Хишиг-Өндөр сумын 11 жилийн сургуулийн монгол хэл, уран зохиолын багш

47. Мөнхөөгийн Оюунчимэг - Нийслэлийн Баянзүрх дүүргийн 44 дүгээр дунд сургуулийн орос хэлний багш

48. Жадамбаагийн Оюунтөгс - Гэмтэл согог судлалын үндэсний төвийн тархи, нуруу нугасны клиникийн эрхлэгч, их эмч

49. Намзаагийн Оюунцэцэг - Нийслэлийн Хан-Уул дүүргийн гадаад хэлний гүнзгийрүүлсэн сургалттай 18 дугаар сургуулийн бага ангийн багш

50. Гэндэнгийн Өлзийсайхан - Архангай аймгийн Жаргалант сумын "Эрдэнэ-Уул" багийн малчин

51. Чунагийн Пунцагдорж - Ус цаг уур, орчны шинжилгээний газрын мэдээлэл, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

52. Манжхүүгийн Пүрэв - Төв аймгийн ХХААГ-ын нягтлан бодогч

53. Намжилын Пүрэвсүрэн - Нийслэлийн Баянгол дүүргийн "Оюуны ундраа" цогцолбор сургуулийн бага ангийн багш

54. Мээдээгийн Сайзмаа - Хилийн 0108 дугаар ангийн тогооч

55. Мягмарын Сарантуяа - Нийслэлийн Баянгол дүүргийн 76 дугаар цэцэрлэгийн эрхлэгч

56. Лувсандагвын Саранчимэг - "Бөртэ" Төрийн өмчит үйлдвэрийн газрын оёдолчин

57. Эрдэнэдалайн Сашка - Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын газар тариалангийн "Баян-Ундарга" ХХК-ийн трактор комбайнч

58. Арвингийн Тарва - Баянхонгор аймгийн Баянхонгор сумын 3 дугаар багийн Засаг дарга

59. Галсангийн Төмөрбаатар - "МИАТ" ХК-

ийн нислэгийн хэлтсийн "26-100" онгоцны II нисгэгч, онгоцны дарга

60. Ширчин-Ойдовын Тунгалаг - Зэвсэгт хүчний Клиникийн төв госпиталийн гэмтэл, бичил мэс заслын тасгийн хагалгаа, боолтын сувилагч

61. Баясгасын Туяат - БХИС-ийн Ар тал техникийн хангалтын албаны дулааны төвийн машинист

62. Содномваанчигийн Усан-Эх - Нийслэлийн Баянзүрх дүүргийн 87 дугаар сургуулийн бага ангийн багш

63. Хүрэн-Алагийн Хангайсайхан - Ус цаг уур, орчны шинжилгээний газрын харъяа Нислэгийн цаг уурын төвийн эрдэм шинжилгээний ажилтан

64. Жамсрангийн Хандмаа - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн математикийн гүнзгийрүүлсэн сургалттай 11 дүгээр сургуулийн биологийн багш

65. Чулуунтөмөрийн Хорлоо - Нийслэлийн Хан-Уул дүүргийн 114 дүгээр сургуулийн монгол хэл, уран зохиолын багш

66. Хавдалхааны Хуанш - Нийслэлийн Чингэлтэй дүүрэг дэх "Нолсан" ХХК-ийн кабельчин

67. Бямбажавын Цэндхүү - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Нэгдсэн эмнэлгийн яаралтай тусламжийн тасгийн сувилагч

68. Халтарын Цэрмаа - БХИС-ийн Ар тал, техникийн хангалтын албаны нярав

69. Сугаржавын Цэрмаа - Улсын Клиникийн төв эмнэлгийн хагалгааны сувилагч

70. Доржсүрэнгийн Цэрэндулам - ШУТИС-ийн Холбоо, мэдээллийн технологийн сургуулийн ахлах багш

71. Ишдоржийн Цэрэндулам - Нийслэлийн хөнгөн үйлдвэрийн "Монгол нэхмэл" ХК-ийн зохион бүтээгч, инженер

72. Төмөрийн Цэцгээ - Өмнөговь аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн сургалтын технологич

73. Бадамын Цолмон - Ус, цаг уур, орчны шинжилгээний газрын мэргэжилтэн

74. Дамдинбазарын Чойдогжамц - Архангай аймгийн Батцэнгэл сумын ахлах сургуулийн математикийн багш

75. Авирмэдийн Энхээ - Нийслэлийн Баянзүрх дүүргийн 44 дүгээр сургуулийн бага ангийн багш

76. Сосорбарамын Энхтуяа - УБТЗ-ын төлөвлөгөө, эдийн засгийн албаны эдийн засагч

77. Жигжидсүрэнгийн Эрдэнэбат - Нийслэлийн Барилга, хот байгуулалт, төлөвлөлтийн газрын цахилгааны инженер

78. Чулууны Эрдэнэбат -Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн сантехникийн слесарь

79. Рэндоогийн Эрдэнэбат - Нийслэлийн холбоо, үйлчилгээний "Монкабель" ХХК-ийн техникч

## ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Ойдовын Амарсанаа - Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн жолооч, ахлах ахлагч
2. Баасанжавын Батаа - Зэвсэгт хүчний 124 дүгээр ангийн ар талын даргын орлогч, авто техникийн дарга, хошууч
3. Хаянхярваагийн Батдорж - Хилийн цэргийн дээд сургуулийн тэнхимийн эрхлэгч, хурандаа
4. Дондовын Батдэлгэр - БХИС-ийн Авто тээврийн тусгай салааны захирагч, сургагч, ахлагч
5. Дагвын Батжаргал - Хилийн 0131 дүгээр ангийн социологи дүн шинжилгээний ажилтан
6. Юндэндоржийн Бат-Очир - Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн станцын дарга-жолооч, ахлах ахлагч
7. Лхамсүрэнгийн Батцагаан - Хилийн 0243 дугаар ангийн тасгийн дарга, дэд хурандаа
8. Луттөмөрийн Баттулга - Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн жолооч, ахлах ахлагч
9. Ламзавын Баярбаатар - Хилийн 0101 дүгээр ангийн ар талын техникийн дарга, дэд хурандаа
10. Дамаагийн Болдсайхан - Хилийн 0214 дүгээр ангийн отрядын төвийн жолооч, ахлах ахлагч
11. Баднайхүүгийн Болдбаатар - Зэвсэгт хүчний 089 дүгээр ангийн жолооч, ахлах ахлагч
12. Батаагийн Болдбаатар - Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын офицер, дэд хурандаа
13. Гүндүүдашийн Булгантамир - Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн биеийн тамир спортын дарга, төлөвлөлтийн офицер, хошууч
14. Төмөрбаатарын Бумантэмүүжин - Хилийн 0101 дүгээр ангийн Алтанбулаг дахь боомтын дарга, дэд хурандаа
15. Аюушийн Буянаа - Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн химийн техник хэрэгсэл хадгалах тасгийн дарга, хошууч
16. Сайжрахын Ганболд - Хилийн 0243 дугаар ангийн заставын дарга, дэд хурандаа
17. Солооны Гончигмаа - Хилийн 0131 дүгээр ангийн цэргийн гал зуухны тасгийн дарга, ахлах ахлагч
18. Шаравын Даваасүрэн - Зэвсэгт хүчний 089 дүгээр ангийн жолооч, ахлах ахлагч
19. Бадарчийн Доржлүрэв - Хилийн 0198 дугаар ангийн зэвсгийн мастер, ахлах ахлагч
20. Ромын Жанибек - Хилийн 0165 дугаар ангийн штабын дарга, дэд хурандаа
21. Шагдарсүрэнгийн Лхагва - Зэвсэгт хүчний 189 дүгээр ангийн холбооны техникч, ахлах ахлагч
22. Дондогийн Мөнхбаяр - Зэвсэгт хүчний 142 дугаар ангийн хөгжимчин, ахлах ахлагч
23. Гэндэнгийн Мөнхжаргал - Хилийн 0253 дугаар ангийн дуучин, ахлах ахлагч
24. Дагмаагийн Нэргүй - Дотоодын цэргийн штабын ахлах офицер, цагдаагийн хошууч
25. Очирын Нямсүрэн - Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн ар талын даргын орлогч, хошууч
26. Ёндонжамцын Отгонбаяр - Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн жагсаал ангийн дарга, хошууч
27. Дагвын Оюунчимэг - Хилийн 0108 дугаар ангийн сургалт хүмүүжил эрхэлсэн орлогч, ахлах дэслэгч
28. Мандахын Очир - Хилийн 0311 дүгээр ангийн албаны дарга, дэд хурандаа
29. Сайнбилэгийн Өлзийтогтох - Зэвсэгт хүчний Хяналт-шалгалт, үнэлгээний газрын хөдөлмөрийн хяналтын байцаагч, дэд хурандаа
30. Бат-Очирын Өнөржаргал - Дорнод аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Цагдаагийн газрын ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа
31. Оросоогийн Сумъяа - Зэвсэгт хүчний Барилгын цэргийн 017 дугаар ангийн блокчин, ахлах ахлагч
32. Хорлоогийн Сүхээ - Нийслэлийн Налайх дүүргийн Онцгой байдлын хэлтсийн аврах, гал унтраах 28 дугаар ангийн нярав, засварчин, дээд түрүүч
33. Ишжамцын Цэцэгмаа - Хилийн 0253 дугаар ангийн албаны дарга, хошууч
34. Сандуйжавын Цэцэгмаа - Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн ахлах тогооч, ахлах ахлагч
35. Цэрэйгийн Шижир - Зэвсэгт хүчний Клиникийн төв госпиталийн нярав-жижүүр, ахлах ахлагч
36. Цэгмидийн Эрдэнэбаатар - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын тоо бүртгэл, нөхөн хангалтын офицер
37. Бүдсүрэнгийн Эрдэнэ-Очир - Хилийн 0214 дүгээр ангийн жолооч, ахлах ахлагч
38. Ёндонгийн Эрдэнэцогт - Хилийн 0252 дугаар ангийн бэлэн байдлын албаны ахлах ажилтан, дэд хурандаа

## "ШУДАРГА ЖУРАМ"

Мижидийн Мөнгөнхундага - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 16 дугаар хорооны өндөр настан, хүндэт донор

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛОГЧ

Н.ЭНХБАЯР



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 03 дугаар сарын 13-ны өдөр

Дугаар 57

Улаанбаатар хот

**Өлзий-Утасын Баярмагнайд Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээх тухай**

Соёл урлаг, батлан хамгаалахын салбарт олон жил үр бүтээлтэй ажиллан, сонгодог болон цэрэг эх орны сэдэвт дууг мэргэжлийн өндөр түвшинд дуулахын зэрэгцээ олон арван дууны ая зохиож, уран бүтээлийн баялаг урын санг бий болгон, Монголын дууны урлагийг баяжуулан хөгжүүлэх, гадаад оронд сурталчлан таниулахад

оруулсан бодитой хувь нэмрийг нь үнэлж Бүх цэргийн дуу, бүжгийн эрдмийн чуулгын гоцлол дуучин Өлзий-Утасын Баярмагнайд Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 03 дугаар сарын 13-ны өдөр

Дугаар 58

Улаанбаатар хот

**Гомбын Мягмарнаранд Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээх тухай**

Мэргэжлийн урлагийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, үндэсний болон гадаадын зохиолчдын шилдэг жүжиг, уран сайхны киноны гол ба туслах дүрүүдийг мэргэжлийн өндөр түвшинд чадварлаг бүтээж, Монголын тайз, дэлгэцийн урлагийн хөгжилд оруулсан бодитой хувь

нэмрийг нь үнэлж Улсын драмын эрдмийн театрын жүжигчин Гомбын Мягмарнаранд Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 03 дугаар сарын 13-ны өдөр

Дугаар 59

Улаанбаатар хот

**Адилбишийн Нэргүйд Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээх тухай**

Соёл урлагийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, Монгол ардын уртын дууг мэргэжлийн өндөр түвшинд дуулан, үндэсний дуулалт жүжгийн гол дүрүүдийг чадварлаг бүтээж, Монгол ардын уртын дууны гайхамшигийг өөрийн орон төдийгүй дэлхий дахинаа сурталчлан таниулах, мэргэжлийн залуу дуучид, уран бүтээгчдийг сургаж

бэлтгэхэд оруулж байгаа онцгой хувь нэмрийг нь үнэлж Үндэсний дуу бүжгийн эрдмийн чуулгын уртын дуучин Адилбишийн Нэргүйд Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 03 дугаар сарын 13-ны өдөр

Дугаар 60

Улаанбаатар хот

**Тувааны Цолмонд Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээх тухай**

Боловсрол, мэргэжлийн урлагийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллан, Монголын төгөлдөр хуурын сургалтыг дэлхийн түвшинд хүргэж хөгжмийн урлагийн өндөр чадвартай, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, орчин үеийн хөгжмийн урлагийг хөгжүүлэх, гадаад оронд сурталчлан таниулах, дэлхийн шилдэг хөгжмийг эх орондоо түгээн дэлгэрүүлэхэд оруулж

байгаа бодитой хувь нэмрийг нь үнэлж СУИС-ийн мэргэжлийн төгөлдөр хуурын багш Тувааны Цолмонд Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 03 дугаар  
сарын 13-ны өдөр

Дугаар 61

Улаанбаатар  
хот

**Баастын Пүрэвт Монгол Улсын  
гавъяат хуульч цол хүртээх тухай**

Төрийн захиргаа, хууль хяналтын байгууллагад олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж, хууль сахиулах байгууллагын бүтэц, тогтолцоог шинэчлэн бэхжүүлэх, тэдгээрийн үйл ажиллагааны эрх зүйн орчинг бүрдүүлэх, Монгол Улсын хууль тогтоомжийг боловсронгуй болгоход

оруулсан хувь нэмрийг нь үнэлж Хууль зүйн ухааны доктор, хошууч генерал Баастын Пүрэвт Монгол Улсын гавъяат хуульч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 03 дугаар  
сарын 13-ны өдөр

Дугаар 62

Улаанбаатар  
хот

**Долгорын Сэд-Очирт Монгол Улсын  
гавъяат эдийн засагч цол хүртээх тухай**

Төрийн захиргааны төв байгууллагуудад он удаан жил санаачилга, үр бүтээлтэй ажиллан, Монгол Улсын хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарыг бэхжүүлэх, ой модны аж үйлдвэрийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэн хөгжүүлэх, улс орныг үйлдвэржүүлэхэд оруулсан

хувь нэмрийг нь үнэлж төрийн захиргааны байгууллагын ахмад ажилтан Долгорын Сэд-Очирт Монгол Улсын гавъяат эдийн засагч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 03 дугаар  
сарын 13-ны өдөр

Дугаар 63

Улаанбаатар  
хот

**Мятавын Лхамсүрэнд Монгол Улсын  
гавъяат эдийн засагч цол хүртээх тухай**

Төрийн захиргааны төв байгууллагад олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарыг хөгжүүлэх, үндэсний боловсон хүчнийг сургаж дадлагажуулах, аж ахуйн тооцоог үйлдвэр, аж ахуйн газарт нэвтрүүлэх, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн системийг шинэчлэх, санхүүгийн эрх зүйн орчинг сайжруулах, төр, засгийн бодлого

шийдвэрийг хэрэгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарын ахмад ажилтан Мятавын Лхамсүрэнд Монгол Улсын гавъяат эдийн засагч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 03 дугаар  
сарын 13-ны өдөр

Дугаар 64

Улаанбаатар  
хот

**Даржаагийн Насанжаргалд Монгол  
Улсын гавъяат эдийн засагч цол хүртээх тухай**

Төрийн захиргаа, хөдөө аж ахуйн салбарт олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж, Монгол Улсын хөдөө аж ахуйн салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох, мал сүргийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх биобэлдмэлийн үйлдвэрлэлд дэвшилтэт техник, шинэ технологи нэвтрүүлэн, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх замаар Монгол Улсын эдийн

засгийн хөгжилд оруулсан хувь нэмрийг нь үнэлж "Биокомбинат" Төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Даржаагийн Насанжаргалд Монгол Улсын гавъяат эдийн засагч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 01 дүгээр  
сарын 07-ны өдөр

Дугаар 05

Улаанбаатар  
хот

### Нийтийн биеийн тамир, спортын талаар авах зарим арга хэмжээний тухай

Биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилгыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. 2009 оны 1 дүгээр сараас эхлэн орон даяар "Биеийн тамир-эрүүл мэнд" уриан дор зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөө, хариуцан ажиллах байгууллагыг хавсралтын ёсоор баталсугай.

2. "Биеийн тамир-эрүүл мэнд" уриан дор зохион байгуулах арга хэмжээний нэгдсэн удирдамжийг баталж, мөрдүүлэхийг Эрүүл мэндийн сайд С.Ламбаа, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Долгор нарт даалгасугай.

3. Дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн сайд С.Ламбаад даалгасугай:

3.1. "Биеийн тамир, спортыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр", Биеийн тамир, спортын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл болон Олимп, дэлхий, тивийн аварга шалгаруулах тэмцээнд амжилт гаргасан тамирчид, түүний дасгалжуулагч, багийн бусад гишүүдэд мөнгөн шагналыг олгох журмын төслүүдийг боловсруулж Засгийн газарт оруулах;

3.2. 2010 оны өвлийн, 2012 оны зуны Олимпын наадамд оролцох Монгол Улсын баг тамирчдын бэлтгэл ажлыг хангах тодорхой хөтөлбөр боловсруулж 2009 оны I улиралд багтаан Засгийн газарт танилцуулах;

3.3. Үндэсний шигшээ багийн тамирчдын бэлтгэл, сургуулийг хангах өвлийн спортын цогцолбор болон "Тамирчдын хотхон" байгуулах зурга төслийг холбогдох яам, Засгийн газрын агентлагтай хамтран боловсруулах;

3.4. биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагыг магадлан итгэмжлэх талаар холбогдох хууль тогтоомжид нэмэлт оруулах асуудлыг судалж шийдвэрлэх;

3.5. олон улсын чанартай тэмцээн, уралдааныг эх орондоо зохион байгуулах боломж бүрдүүлэх зорилгоор аймаг, нийслэлийн зарим дүүрэгт баригдах спортын цогцолборыг спортын тодорхой төрлөөр төрөлжүүлэх, усан бассейнтай болгох талаар арга хэмжээ авах.

4. Дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Е.Отгонбаярт үүрэг болгосугай:

4.1. бүх шатны боловсролын байгууллагын биеийн тамирын сургалтыг хүүхэд, залуучуудыг чийрэгжүүлэх, бие бялдрын хөгжлийг хангах гол хэрэгсэл болгон хөгжүүлэх, хүүхдийн бие бялдрын хөгжлийн түвшин тогтоох сорилыг сургалтын хөтөлбөрт оруулах;

4.2. хичээлийн бус цагаар спортын секц, дугуйлан ажиллуулах, гүнзгийрүүлсэн сургалттай анги нээж хичээллүүлэх, сургуулийн болон дотуур байрны гадна талд дасгал, хөдөлгөөн хийх талбай

байгуулах зэрэг боловсролын байгууллагын санал санаачилгыг бүх талаар дэмжиж ажиллах.

5. Дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Е.Отгонбаяр, Эрүүл мэндийн сайд С.Ламбаа нарт үүрэг болгосугай:

5.1. бүх шатны сургуулийн биеийн тамирын тэнхим, заах аргын нэгдлийн багш нарыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах асуудлыг биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран шийдвэрлэх талаар журам боловсруулж мөрдүүлэх;

5.2. биеийн тамирын багш, дасгалжуулагчийг сургалтын төрийн сан, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр гадаад оронд мэргэжил дээшлүүлэх, урт, богино хугацааны сургалтад хамруулах;

5.3. ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын хичээлийн чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор спортын заал, танхим, хэрэглэл, материалын стандартыг шинэчлэн боловсруулж, биеийн тамирын заал, танхим, гадна талбайн ашиглалтыг сайжруулах, биеийн тамирын багш нарыг холбогдох сурах бичиг, гарын авлагаар хангах.

6. Дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай:

6.1. иргэд биеийн тамир, спортоор хичээллэхэд зориулан гүйлт, алхалтын зам, дасгал, хөдөлгөөн хийх ногоон байгууламж бүхий ил талбай байгуулж, өвлийн улиралд байгалийн болон хиймэл мөс, цасан талбайг харьяа нутаг дэвсгэрийнхээ орон сууц, гэр хорооллын орчимд байгуулж, тогтмол ажиллуулах;

6.2. биеийн тамир, спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын санаачилгыг бүх талаар дэмжиж ажиллах;

6.3. аймаг, нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын байгууллагын үйл ажиллагааг идэвхжүүлж, чадавхийг нь дээшлүүлэх арга хэмжээ авах;

6.4. сумын соёл-спортын төв, аймаг, дүүргийн спортын ордонд иргэд биеийн тамир, спортоор хичээллэх, уралдаан тэмцээн зохион байгуулах таатай орчин бүрдүүлэх арга хэмжээ авах;

6.5. улсын хэмжээнд ашиглагдаж байгаа нийтийн биеийн тамир, спортын заал, танхим, гадна талбайн ашиглалтыг сайжруулах, цаашид зориулалтыг өөрчлөх, бусдад шилжүүлэх, худалдахыг хориглох чиглэлээр тодорхой арга хэмжээ авах.

7. Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг улсын болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлэхийг Засгийн газрын холбогдох гишүүд, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

8. Энэхүү тогтоолын хэрэгжилтийн явцыг жил бүрийн 12 дугаар сард багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Эрүүл мэндийн сайд С.Ламбаад даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

С.ЛАМБАА



Засгийн газрын 2009 оны 5 дугаар  
тогтоолын хавсралт

**“БИЕЙН ТАМИР-ЭРҮҮЛ МЭНД” УРИАН ДОР ЗОХИОН БАЙГУУЛАХ  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ, ХАРИУЦАН АЖИЛЛАХ БАЙГУУЛЛАГА**

Сар	Үйл ажиллагааны чиглэл	Удирдан чиглүүлэх яам	Хамтран зохион байгуулах байгууллагууд
I	«өвлийн спортыг дэмжих сар»	БХЯ, бүх шатны Засаг дарга	-Сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг -Биеийн тамир, спортын газар -Аймаг, нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын байгууллага
II	«Биеийн тамир, спортыг дэмжигч ажлын байр» хөдөлгөөнийг дэмжих сар	ЭБЭХЯ, бүх шатны Засаг дарга	-Сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд -Биеийн тамир, спортын газар -Аймаг, нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын байгууллага
III	«Бие бялдрын соёл, боловсрол»-ыг дэмжих сар	БСШУЯ, бүх шатны Засаг дарга	-Сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг -Биеийн тамир, спортын газар -Аймаг, нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын байгууллага
IV	«Идэвхтэй хөдөлгөөн-Эрүүл аж төрөх ёс»-ыг сурталчлах сар	ЭМЯ, бүх шатны Засаг дарга	-Сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд -Биеийн тамир, спортын газар -Аймаг, нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын байгууллага
V	«Эрүүл мэндийн гүйлт»-ийг дэмжих сар	СЯ, бүх шатны Засаг дарга	-Сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд -Биеийн тамир, спортын газар -Аймаг, нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын байгууллага
VI	«Монголын тамирчдын өдөр», «Олимпын хөдөлгөөн»-ийг дэмжих сар	ЗГХЭГ, бүх шатны Засаг дарга	-Сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд -Биеийн тамир, спортын газар -Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар -Аймаг, нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын байгууллага -Монголын үндэсний олимпын хороо
VII	«Үндэсний спортыг дэмжих сар»	ХЗДХЯ, бүх шатны Засаг дарга	-Сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд -Биеийн тамир, спортын газар -Аймаг, нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын байгууллага
VIII	«Явган аяллыг дэмжих сар»	БОАЖЯ, бүх шатны Засаг дарга	-Сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд -Биеийн тамир, спортын газар -Аймаг, нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын байгууллага
IX	«Ахмадын биеийн тамир»-ыг дэмжих сар	НХХЯ, бүх шатны Засаг дарга	-Сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд -Биеийн тамир, спортын газар -Аймаг, нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын байгууллага
X	«Эрүүл мэндийн алхалт» Дэлхийн алхалтын өдрийг дэмжих сар	ГХЯ, бүх шатны Засаг дарга	-Сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд -Биеийн тамир, спортын газар -Аймаг, нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын байгууллага
XI	«Тохитой орчин-идэвхтэй хөдөлгөөн»-ийг дэмжих сар	ЗТБХБЯ, бүх шатны Засаг дарга	-Сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд -Биеийн тамир, спортын газар -Аймаг, нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын байгууллага
ХП	«Зохистой хооллолт-идэвхтэй хөдөлгөөн»-ийг дэмжих сар	ХХААХҮЯ, бүх шатны Засаг дарга	-Сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд -Биеийн тамир, спортын газар -Аймаг, нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын байгууллага

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

### Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь: 1. "Монголын уламжлалт бий, биелгээ" хөтөлбөрийг 1 дүгээр хавсралтын ёсоор, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралтын ёсоор, хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд уялдуулах үүрэг бүхий Зохицуулах хорооны бүрэлдэхүүнийг 3 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. "Монголын уламжлалт бий, биелгээ" хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг 2010 оноос эхлэн улсын төсөвт жил бүр тусгаж, хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах, дотоод, гадаадын төрийн болон төрийн бус

байгууллагуудтай хамтран ажиллахыг Зохицуулах хорооны дарга бөгөөд Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Е.Отгонбаярт даалгасугай.

3. "Монголын уламжлалт бий, биелгээ" хөтөлбөрийг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАЯР**

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААНЫ САЙД**

**Е.ОТГОНБАЯР**

**Засгийн газрын 2009 оны 10 дугаар  
тогтоолын 1 дүгээр хавсралт**

### "МОНГОЛЫН УЛАМЖЛАЛТ БИЙ, БИЕЛГЭЭ" ХӨТӨЛБӨР

#### Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого, Төрөөс баримтлах соёлын бодлого, Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хуульд ардын уламжлалт урлагийг төрийн ивээлд байлгаж, тэдгээрийг судлах, сургаж эзэмшүүлэх, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, утга соёлын өв тээгчдийг тодруулан алдаршуулах, тэдэнд дэмжлэг үзүүлэх талаар заасан байдаг.

Монгол Улс морин хуурын уламжлалт урлагийг 2003 онд, монгол ардын уртын дууг 2005 онд хүн төрөлхтний утга соёл, аман өвийн шилдэг дээжист тунхаглуулж, ЮНЕСКО-гийн батламж авсан билээ. Монгол Улсын Засгийн газраас "Ардын уламжлалт урлагийг дэмжих үндэсний хөтөлбөр" (1999-2006 он)-ийг хэрэгжүүлж дууссан бөгөөд "Морин хуур, уртын дуу", "Монгол хөөмий" хөтөлбөр хэрэгжүүлж байна.

Гэвч ардын уламжлалт урлаг, биет бус соёлын өвийн олон төрөл, зүйлд иж бүрэн хандаж, тэдгээрийг адил тэнцүү хадгалж хамгаалах асуудал шаардлагын хэмжээнд хүрэхгүй байна. Үүний нэг жишээ нь Монголчуудын баяр жаргал, амьдрал тэмцэл, ахуй байдал, ёс заншлын илэрхийлэл болж, өнө эртнээс өнөөг хүртэл үе залган уламжилж ирсэн үндэсний уламжлалт бүжгийн ховор хосгүй төрөл болох бий,биелгээний уламжлал мартагдахад хүрч, язгуур бийч-биелээчид цөөрсөөр байна. Монголын олон ястны уламжлалт бүжиг, бий, биелгээний өөр өөрийн өвөрмөц онцлог, ялгаа зааг бүдгэрч, хуур, икэлийн уламжлалт татлагууд мартагдан гээгдэж байна.

Төв, орон нутгийн урлаг, соёлын байгууллагын урын санд түгээмэл байдаг "биелэг", "баруун монгол биелгээ" зэрэг тайзны бүжгүүдийн олонхи нь олон ястны бий, биелгээний ялгаа, заагийг нарийн гаргаагүйгээс язгуур намба төрхийг алдагдуулж, агуулга, хэлбэрийг бүдгэрүүлжээ.

Цөөн тооны авъяастнууд баяд, дөрвөд, захчин, казах, хотон, урианхайн бий, биелгээ, буриадын ёхор зэрэг уламжлалт бий, биелгээ, бүжгийг хадгалж хамгаалан, залуу үедээ өвлүүлэх талаар хичээн зүтгэж байгаа боловч тэдгээрийг төрөөс нэгдсэн бодлогоор дэмжих арга, хэлбэр бүрэн төлөвшөөгүй байна.

Монгол ардын язгуур бий, биелгээг хадгалж хамгаалах, үеэс үед өвлүүлэх, бий, биелгээний гэрийн болон шавь сургалт, албан болон албан бус сургалтыг өргөжүүлэх, өвлөн тээгч-бийч-биелээчдийг тодруулан алдаршуулах, дэмжих чиглэлээр тодорхой үйл ажиллагаа явуулж, утга соёлын өвийг баяжуулан хөгжүүлэх зорилгоор "Монголын уламжлалт бий, биелгээ" хөтөлбөрийг боловсруулав.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт

#### 2.1. Хөтөлбөрийн зорилго

Энэхүү хөтөлбөрийн зорилго нь Монголын уламжлалт бий, биелгээний урлагийг судалж сурталчлах, хадгалж хамгаалах, уламжлал өвлүүлэх, бий, биелгээний дэг жаяг, арга маягийг сургаж эзэмшүүлэх, хөгжүүлэх ажлыг соёл урлаг, боловсролын байгууллага, уран бүтээлч, ардын авъяастны дунд өрнүүлэн дэлгэрүүлж улмаар түүний үндэсний болон олон улсын түвшинд эзлэх байр суурийг бэхжүүлэх явдал юм.

#### 2.2. Хөтөлбөрийн зорилтууд

- 2.2.1. Монголын уламжлалт бий, биелгээ, бийч-биелээчийн судалгаа явуулах;
- 2.2.2. Монголын уламжлалт бий, биелгээний сургалт, сурталчлагаа явуулах;
- 2.2.3. Бийч-биелээчдэд дэмжлэг үзүүлж, тэднийг тодруулан алдаршуулах, бий, биелгээг өвлүүлэн хөгжүүлэх.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зам

3.1.1. Монголын уламжлалт бий, биелгээ болон түүний уламжлалт урын санг өвлөн эзэмшсэн



билиг авъяастны судалгаа явуулж, улс, аймаг, нийслэл, байгууллагын бүртгэл-мэдээлэл, аудио, видео сан бүрдүүлэх

3.1.2. Бий, биелгээний албан болон албан бус, шавь болон гэрийн сургалт зохион байгуулах, бий, биелгээний урлагийн үзлэг, уралдаан, наадам, уулзалт, симпозиум, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, уламжлалт бий, биелгээ, бийч-биелээчийн талаархи танилцуулга, цомог, ном, товхимол гаргах сурталчлах;

3.1.3. Бийч-биелээчдийг тодруулах, тэдгээрийг хөхиүлэн дэмжиж алдаршуулах, шагнаж урамшуулах, ажиллах орчныг бүрдүүлэх арга хэмжээ авах;

3.2. Бий-биелгээний судалгааг дараах чиглэлээр явуулна.

3.2.1. Монголын уламжлалт бий, биелгээний үүсэл гарвалын судалгаа;

3.2.2. Монголчуудын уламжлалт бүжгийн урлаг, оюуны сэтгэлгээнд бий, биелгээний гүйцэтгэсэн үүрэг, түүхэн ач холбогдол;

3.2.3. Бий, биелгээний тархалт болон нутаг, нутгийн хувилбарууд, олон ястны бий, биелгээний төрөл, зүйл, өвөрмөц онцлог, дэг сургууль, донж маяг, тэдгээрийн харьцуулсан судалгаа;

3.2.4. Бий, биелгээний уламжлалт татлагууд, хуур (икэл, товшуурын) бий, биелгээ болон ардын аман билгийн бусад төрлүүдийн уялдаа холбоо;

3.2.5. Бий, биелгээний гэрийн болон шавь сургалт, заах арга зүйн уламжлал, шинэчлэл;

3.2.6. Бий, биелгээний уламжлалаас суралцах, бүтээлчээр хөгжүүлэх, уламжлал, шинэчлэлийг зохистой хослуулах арга замын судалгаа;

3.2.7. Бийч-биелээчийн түүх, шаштир, биелэх ур чадварын судалгаа;

3.2.8. Бий, биелгээ болон монголчуудын хэв заншил, бэлгэдэл, зан үйл, төр ёсны уламжлалын холбоо;

3.2.9. Хөрш зэргэлдээ улсын ард түмний аман болон биет бус соёлын өвд бий, биелгээний урлагийн үзүүлсэн нөлөө, харилцан хамаарал.

3.3. Бий, биелгээний урлагийн сургалт, сурталчилгаа.

3.3.1. Төв, орон нутгийн соёл, боловсролын байгууллагууд бий, биелгээний албан болон албан бус сургалт зохион байгуулах, шавь болон гэрийн сургалтыг сэргээн хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

3.3.2. Бий, биелгээ, бийч-биелээчийн тухай танилцуулга, цомог, ном, CD, DVD гаргах, цуврал баримтат кино бүтээж сурталчлах;

3.3.3. Бий, биелгээний уламжлалт урлагийн төрөл, зүйлийг сурвалжлан олж илрүүлэх, судлан сурталчлах, бийч-биелээчийг тодруулан алдаршуулах, тэдгээрт дэмжлэг үзүүлэх, бий, биелгээний урлагийг өвлүүлэн хөгжүүлэх зорилгоор төв, орон нутаг, үндэсний хэмжээнд үзлэг, уралдаан, наадам, уулзалт, ярилцлага, симпозиум, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах;

3.3.4. Уламжлалт бий, биелгээ, бийч-биелээчийн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр үе шаттай сурталчлах.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага.

зохион байгуулалт

4.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд уялдуулан зохицуулах явцад хяналт тавих үүргийг хөтөлбөрийн Зохицуулах хороо гүйцэтгэнэ.

4.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулж, мэргэжил-арга зүйн удирдлагаар хангаж ажиллах үүргийг Соёл, урлагийн хороо гүйцэтгэнэ.

4.3. Орон нутагт "Монголын уламжлалт бий, биелгээ" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохицуулах салбар хороо аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга байгуулан ажиллуулна. Салбар хорооны бүрэлдэхүүн, түүний чиг, үүргийг Засаг дарга батлан гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллана.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

"Монголын уламжлалт бий, биелгээ" хөтөлбөрийг 6 жилийн (2009-2014 он) хугацаанд хэрэгжүүлнэ.

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлт, санхүүжилт "Монголын уламжлалт бий, биелгээ" хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Соёл, урлагийн хороо холбогдох төрийн болон төрийн бус байгууллага (аймаг, нийслэл, мэргэжлийн эвлэл, холбоо, төв, студи зэрэг)-тай хамтран хэрэгжүүлнэ. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. -улсын төсөв (Соёл, урлаг хөгжүүлэх сангийн хөрөнгө);

-гадаад орон, олон улсын байгууллагын хандив, тусламж;

-төрийн болон төрийн бус байгууллага, иргэдээс оруулсан хандив, тусламжийн хөрөнгө.

Долоо. Хөтөлбөрийн үр дүн

7.1. Бий, биелгээний урлагийг өвлөсөн ардын билиг авъяастны үйл ажиллагааг дэмжиж, тэдний авъяас билиг, арга барил, дэг сургуулийг хадгалж хамгаалан хөгжүүлэх ажлын шинэ тогтолцоо бүрдэнэ.

7.2. Бий, биелгээний урлагийн мартагдаж байгаа өв уламжлалыг сэргээх, өвлөн хөгжүүлэх үйл ажиллагааны түвшин дээшилж, хамрах хүрээ, далайц, хүртээмж нэмэгдэнэ.

7.3. Бий, биелгээний урлагийн судалгаа, сургалт, сурталчилгаа эрчимжиж, суурь болон хавсарга судалгааны тоо, чанарт ахиц гарч уг чиглэлээр олон улсын болон улс, бус нутаг, орон нутгийн хэмжээнд зохиох арга хэмжээний менежмент боловсронгуй болно.

7.4. Улс, аймаг, нийслэл, холбогдох байгууллага бий, биелгээний бүртгэл-мэдээллийн сантай болж, сонирхогч, ардын авъяастан, уран бүтээлчдийн эрэлт хэрэгцээг хангах, тэдэнд үйлчлэх материаллаг бааз болон оюуны орчин бий болно.

7.5. Бий, биелгээний урлаг сэргэж, монгол үндэстэн, угсаатан, ястны соёлын нэгэн хэрэглээ болж, ардын билиг авъяастан, мэргэжлийн урлагийн байгууллагуудын урын сан баяжиж, үндэсний хэмжээнд бий, биелгээний урлагийн эзлэх байр суурь дээшилнэ.

Найм. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүд  
 8.1. «Монголын уламжлалт бий, биелгээ» хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг аймаг, нийслэлийн Засаг дарга нар баталсан байх;  
 8.2. соёлын өвийн улсын нэгдсэн болон байгууллага, аймаг, нийслэлийн бүртгэл-мэдээллийн санд бий, биелгээний урлагийн талаархи бүртгэл-мэдээлэл бий болсон байх;

8.3. зарим аймаг, сум, дүүрэг, ерөнхий

боловсролын сургуульд бий, биелгээний албан болон албан бус сургалт явуулсан байдал;

8.4. бий, биелгээний урлаг сэргэж, концертын байгууллага, уламжлалт урлагийн хамтлагууд бийч-биелгээтэй болсон байх;

8.5. бий, биелгээ, уламжлалт бүжгийн урлагийн чиглэлээр зохион байгуулсан бус нутаг, улс, олон улсын уралдаан, наадмын менежментийн түвшин;

8.6. бий, биелгээний урлагийг сонирхогч, ардын авьяастан, бийч-биелгээний тоо өссөн байдал.

Засгийн газрын 2009 оны 10 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

## "МОНГОЛЫН УЛАМЖЛАЛТ БИЙ, БИЕЛГЭЭ" ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэх хугацаа (оноор)	Сэнхүүжилт (сая.төг)	Сэнхүүжилтийг хариуцах байгууллага	Арга хэмжээг зохион байгуулах хугацаа
Нэг. Бий, биелгээний урлагийн судалгааны талаар					
1.1	Бий, биелгээний урлагийн судалгааны үндэсний багийн төмөрлөн ажиллуулна	2009	-	Боловсрол, соёл, шинжлэх ухааны нам	Боловсрол, соёл, шинжлэх ухааны нам, Зохицуулах хороо
1.2	Үндэсний багаас хэзэрийн шинжлэгээ, судалгаа хийх ажлын төлөвлөгөө, төсөв боловсруулж батлуулан хэрэгжүүлнэ	2009-2011	6.0	Шинжлэх ухаан, технологийн сан	Бий, биелгээний урлагийн судалгааны үндэсний баг
1.3	Монголын утга соёлын өвийн мэдээ, судалгааны судли байгуулна	2011-2013	12.0	Соёл, урлаг хөгжүүлэх сан, Шинжлэх ухаан, технологийн сан, гадаадын хөрөнгө оруулалт	"Бий-биелгээ" холбоо Соёлын өвийн төв болон Морин, хуур, уртын дуу, хөмийн, бий, биелгээ зэрэг уламжлалт урлагийн төрөл зүйлийг хөгжүүлэх хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг зохион байгуулах зөвлөл, хороо Соёлын өвийн төв, Засаг даргын Тамгын газар, мэргэжлийн урлагийн байгууллага, сумдын соёлын төв
1.4	Монголын уламжлалт бий, биелгээ болон түүний уламжлалт урын санд өвлөн эзэмшсэн биеийг авьяастны судалгаа явуулсны үндсэн дээр улс, аймаг, нийслэл, сум, байгууллагын бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлж, жил тутамд бэлэвүүлнэ	2009-2014	Туайн байгууллагын жилийн төсөв	Соёлын өвийн төв, аймаг, нийслэл, сумын Засаг даргын Тамгын газар	Соёлын өвийн төв, аймаг, нийслэл, сумын Засаг даргын Тамгын газар, мэргэжлийн урлагийн байгууллага, сумдын соёлын төв
Хоёр. Бий, биелгээний сургалт, сурталчилгааны талаар					
2.1	"Монголын уламжлалт бий, биелгээ" хөтөлбөрийн агуулга, зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар холбогдох байгууллага, агентуудын дунд сургалт, семинар зохион байгуулна	2009	2.5	Соёл, урлаг хөгжүүлэх сан	Боловсрол, соёл, шинжлэх ухааны нам, Соёл, урлагийн хороо
2.2	Бий, биелгээний судалгааны ном, товчимол, CD, VCD хэвлүүлнэ	2010 2012 2015	6.0	Соёл, урлаг хөгжүүлэх сан, технологийн сан	Соёлын өвийн төв, "Бий-биелгээ" холбоо
2.3	Гэрмийн болон шавь сургалтыг хөгжүүлж дамжих, зарим сургуульд бий, биелгээний сургалт явуулах арга хэмжээ авна	2009-2014	Байгууллагын төсөв	Аймагийн Боловсрол, соёлын газар, Нийслэлийн соёл, урлагийн газар	Аймагийн Боловсрол, соёлын газар, Нийслэлийн соёл, урлагийн газар, Боловсролын газар, ерөнхий боловсролын сургуулиуд

2.4	Бий биеллэг, бийн-биелзэндэйн таницуулга, цраг болгаж хэлүүлнэ	2009-2010	4.0	Нүүдэдийн соёл иргэшлийг судлах олон улсын хурал, Шингэлз ухаан, технологийн сан	Бий, биелзэний урлагийн судалгааны үндэсний бий, "Бий-биелзэг" холбоо
2.5	Монголын уламелатт бий, биелзэний наадам зохион байгуул	2009	6.0	Соёл, урлаг хөгжүүлэх сан, ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисс	Боловсрол, соёл, шингэлэх ухааны лам, Зохицуулах хороо, ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисс
2.6	Бий, биелзэний наадамг Увс, Ховд, Баян-Өлгий, Хөвсгөл, Сүхбаатар, Хэнтий аймагт бүсчлэн зохион байгуулна.	2010-2014	30.0	Соёл, урлаг хөгжүүлэх сан, аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн Боловсрол, соёлын газар	Зохицуулах хороо, аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсрол, соёлын газар, "Бий-биелзэг" холбоо
2.7	Монгол угсаатны уламелатт бүжгийн Олонулсын наадамг Монгол Улсад зохион байгуулна	2011	45.0	Соёл, урлаг хөгжүүлэх сан, ЮНЕСКО, падаадын байгууллагууд	Боловсрол, соёл, шингэлэх ухааны лам, Соёл урлагийн хороо, Зохицуулах хороо, Бүжгийн нийгэмлэг, "Бий-биелзэг" холбоо
2.8	Бий, биелзэний урлагийн тухай цэрал баримтат кино бүтээнэ	2010-2014	5.0	Соёл, урлаг хөгжүүлэх сан, Шингэлз ухаан, технологийн сан	Зохицуулах хороо, "Монгол кино" нэгтгэл, "Соёл-Эрдэнэ" студи
2.9	Монголын уламелатт бүжгийн бeш нэрэг мэргэжил дэвшүүлэх, давтан сургах сургалтад үе шаттай хамруулна	2010-2014	16.0	Соёл, урлаг хөгжүүлэх сан	Соёл урлагийн хороо, Соёл, урлагийн их сургууль, Соёлын дээд сургууль, Хөгжим, бүжгийн коллеж, СУИС-ийн харьяа Зашаан аймаг дахь Хөгжим, бүжгийн коллеж
2.10	Бий, биелзэний урлагийг гаралдад сурталчлах, аялал жуулчлалын бусгагчдын болгох боломжийг судалж хэрэглүүлнэ	2010-2014	30.0	Боловсрол, соёл, шингэлэх ухааны яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисс	Боловсрол, соёл, шингэлэх ухааны яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисс

Гэрээ, бий, биелзэний урлагийн хэдгэлж хамгаалах, бийн-биелзэндэйн дэмжлэг талар

3.1	Бий, Биелгэний Урлагийг Хүн төрөлхтэй аман болон биет бус соёлын өвийн шилдэг дэмжлэг өргөмжлөн, тунхагуулах өргөдөл, санал боловсруулж ЮНЕСКО-д уламжилна	2010-2012	8.0	ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комисс, Соёлын өвийн төв	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комисс, Соёлын өвийн төв
3.2	Аймаг, нийслэлийн Боловсрол соёлын болон соёл урлагийн газар бий, биелгэний урлагийг хадгалж хамгаалах төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ	2010-2014	Өөрийн төсөв	Аймаг, нийслэлийн Засаг дарлын Тамгын газар	Аймаг, нийслэл, дүүрэг, сумын Засаг дарлын Тамгын газар, соёл, боловсролын байгууллагууд
3.3	Аймаг, нийслэл, сум, дүүрэг бүр ардын Буюу, бие лгээ сонирхогч авъяастнуудаа судлан тодруулж, тэдэнд дэмжлэг үзүүлж ажиллана	2009-2014	Өөрийн төсөв	Аймаг, нийслэл, сум, дүүрэг	Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Боловсрол, соёлын болон Соёл, урлагийн газар
3.4	Бий, Биелгэний урлагийг ур чадварын өндөр түвшинд өвлөн тээж, шавь болон гэрийн сургалт явуулан ур чадвар бүхий явуулан ур байгаа авъяастнуудыг урамшуулах, тэдэнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авна	2010-2014	Тухайн үед шийдвэрлэнэ	Соёл, урлаг хөгжүүлэх сан, ЮНЕСКО	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Зохицуулах хороо, ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комисс
3.5	Монголын уламжлалт бий, биелгэний хөвөр, хосгүй өвийг хадгалж хамгаалах, шавь нартаа зааж өвлүүлэн сурталчлах үйлсэд амжилт гаргасан ардын авъяастан, уран бүтээлчийг хөгжүүлэн дэмжиж, төр засаг, байгууллагын шалчлаар шагнуулах арга хэмжээг зохион байгуулна	2009-2014	Тогтсон журмын дагуу	Соёл, урлаг хөгжүүлэх сан, аймаг, нийслэлийн Засаг дарлын Тамгын газар,	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, аймаг, нийслэлийн Засаг дарлын Тамгын газар, Боловсрол, соёлын газар
3.6	Уламжлалт бүжгийн Олон улсын наадам, уралдаан, тэмцээнд Монголын бүжгчид, бийч-биелээчдийг дэмжин оролцуулна	2009-2014	Улсын төсөв, хандийн тусламж	Соёл, урлаг хөгжүүлэх сан, гадаадын байгууллагууд	Зохицуулах хороо, "Бий-Биелэг" холбоо
3.7	Бий, Биелгэний урлагийг дэмжих асуудлыг ЮНЕСКО-гийн "Хүн-Эрдэнэ" хөтөлбөрт хамруулах арга хэмжээ авна	2010-2014	ЮНЕСКО	ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комисс	ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комисс, Соёл, урлагийн хороо, Соёлын өвийн төв
3.8	Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад жил бүр хандалт-шинжилгээ, үнэлгээ хийнэ	2009-2014	Улсын төсөв	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам

**Засгийн газрын 2009 оны 10 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт**

**"Монголын Уламжлалт Бий, Биелгээ" Хөтөлбөрийг улсын хэмжээнд уялдуулан Зохицуулах хорооны бүрэлдэхүүн**

Дарга: - Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд

Гишүүд: - ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комиссын Ерөнхий нарийн бичгийн дарга;

- Соёл, урлагийн хорооны дарга;
- Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Соёл, урлагийн бодлогын газрын дарга;
- Нийслэлийн Соёл, урлагийн газрын дарга;
- Үндэсний дуу, бүжгийн эрдмийн чуулгын дарга;
- Соёл, урлагийн их сургуулийн захирал;
- Соёл, урлаг судлалын хүрээлэнгийн захирал;

- Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэнгийн захирал;

- Соёлын дээд сургуулийн захирал;
- Хөгжим, бүжгийн коллежийн захирал;
- Соёлын өвийн төвийн захирал;
- Утга соёлын өвийн үндэсний төвийн тэргүүн (тохиролцсоноор);
- Монголын урлагийн ажилтны холбооны нийгэмлэгийн тэргүүн (тохиролцсоноор).

Нарийн бичгийн дарга: - Соёл, урлагийн хорооны утга соёлын өвийн бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

## Хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай

"Атрын гурав дахь аян" тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийн үр дүн, үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Дор дурдсан асуудлаар холбогдох хуулийн төсөл боловсруулж 2009 оны I улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд оруулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, Сангийн сайд С.Баярцогт, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж нарт даалгасгай;

а) Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрийг бүхэлд нь, Төв, Булган, Орхон, Хөвсгөл, Дорнод аймгийн нутаг дэвсгэрийн тодорхой хэсгийг эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан хослон хөгжүүлэх бүс нутаг болгох;

б) газар тариалангийн зориулалттай импортын техник, тоног төхөөрөмж, үр, бордоо, ургамал хамгааллын бодисын нийлүүлэлтийг технологийн хугацаанд нь багтаан хангахтай холбоотой зохицуулалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд тусгах;

в) үр тариа, төмс, хүнсний ногооны хангамжийг нэмэгдүүлж дотоодын үйлдвэрлэлээр хэрэгцээг хангах зорилгоор импортын гурил, буудай, төмс, хүнсний ногооны гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын хувь, хэмжээг улирлын ялгавартай тогтоох эрхийг Засгийн газарт олгох.

2. Үр, бордоо, өндөр хүч чадлын техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлийн бодлогоор газар тариалангийн салбарт хэрэгжүүлэхдээ гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, зээл, тусламж авах, санхүүгийн түрээс (лизинг)-ийн үйлчилгээг холбогдох хууль тогтоомжийн дагуу ашиглах замаар шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд С.Баярцогт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, Гадаад харилцааны сайд С.Батболд нарт даалгасгай.

3. Дор дурдсан үйл ажиллагаа хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Е.Отгонбаяр, Сангийн сайд С.Баярцогт, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди, Гадаад харилцааны сайд С.Батболд нарт үүрэг болгосгай;

а) Оросын Холбооны Улс, Канад Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс зэрэг газар тариалан өндөр хөгжсөн орнуудад тариалангийн салбарын 30 хүртэл менежер, мэргэжилтэн жил бүр сургаж, зардлыг нь аж ахуйн нэгжүүдийн өөрийн хөрөнгөөр болон холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцаас санхүүжүүлэх;

б) мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийн сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, материаллаг баазыг нь бэхжүүлэх замаар механикжуулах, ногоочдыг сургах, давтан сургах;

в) хувиараа болон өрхийн, эсхүл нөхөрлөл, хоршооны хэлбэрээр газар тариалангийн аж ахуй эрхлэх, үйлдвэрлэлээ өргөтгөж ажлын байр шинээр нэмэгдүүлэхэд зориулан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зохих хууль тогтоомж, журмын дагуу дэмжлэг үзүүлэх;

4. Дор дурдсан арга хэмжээг зохион байгуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосгай;

а) Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Увс, Ховд, Завхан, Говь-Алтай, Баян-Өлгий аймгуудад услагатай үр тариа, төмс, хүнсний ногоо, малын тэжээлийн ургамлын тариалалтыг нэмэгдүүлэх, техник, тоног төхөөрөмж, үр, бордоо, ургамал хамгааллын бодисын хүрэлцээ, хангамжийг сайжруулах замаар хурааж авах ургацын хэмжээг өсгөж аймаг болон бүс нутгийн дотоодын хэрэгцээг хангах нөхцөлийг бүрдүүлэх;

б) Улаанбаатар хот болон хүн ам төвлөрсөн томоохон хот, суурин газруудад төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, хамгаалагдсан хөрсний эрчимжсэн аж ахуй хөгжүүлэх, агуулах болон зоорийн аж ахуй байгуулах, борлуулалтын сүлжээ бий болгох;

в) тэжээлийн ургамлын тариалалтыг нэмэгдүүлэн мах, сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуйн нэгжүүдийг хот, суурин газрын бүсэд шинээр байгуулах замаар хүн амын мах, сүүний хангамжийг сайжруулах.

5. Хүнсний буудайн стратегийн нөөц бүрдүүлэх зорилгоор жил бүр 120.0-150.0 мянган тонн хүнсний буудай худалдан авах, тариалангийн бүсүүдэд байгаа элеватор, агуулахыг засварлаж бэлэн болгох, шинээр элеватор барих асуудлыг судалж үе шаттайгаар шийдвэрлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, Сангийн сайд С.Баярцогт нарт үүрэг болгосгай.

6. Тариалангийн газрын ашиглалтыг сайжруулах, хөрсний үржил шимийг хамгаалах цогц арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүх нарт даалгасгай.

7. Энэхүү тогтоолын биелэлтийг жил бүрийн 12 дугаар сард Засгийн газрын хуралдаанд танилцуулж байхыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Долгор нарт үүрэг болгосгай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН  
САЙД

Т.БАДАМЖУНАЙ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас эрхлэн гаргах.  
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн редакци.

Улсын Их Хурлын Тамгын газрын  
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12  
Төрийн ордон-128 тоот

☎ 262420, 329612  
Индекс 14003

☎ 329487

Хэвлэлийн хуудас 2